



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/100

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер хүчингүй болгож, дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар зөвлөмжийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2019 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн 13 дугаар багц ороох боох уламжлалт зүү, уян зүүг 87906600 (наян долоон сая есөн зуун зургаан мянга зургаан зуу) төгрөгөөр Сүвэн-Уул ХХК-иар, 17 дугаар багц анестезлогийн хэрэгслийг 23014640 (хорин гурван сая арван дөрвөн мянга зургаан зуун дөч) төгрөгөөр Чоногол трейд ХХК-иар, 18 дугаар багц рентгений хэрэгслийг 33075000 (гучин гурван сая далан таван мянга) төгрөгөөр Саммитмедикал сервис ХХК-иар, 20 дугаар багц гистологи-цитологийн урвалжыг 7747500 (долоон сая долоон зуун дөчин долоон мянга таван зуу) төгрөгөөр Монгол фарм ХХК-иар, 22 дугаар багц ДН-36 аппаратны урвалжыг 6725000 (зургаан сая долоон зуун хорин таван мянга) төгрөгөөр Сүвэн-Уул ХХК-иар, 23 дугаар багц биохими humastar 200, humalazer-3500 аппаратны урвалжыг 25070900 (хорин таван сая далан мянга есөн зуу) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар, 24 дүгээр багц иммунологийн урвалж (star fax elisa)-ийг 44478500 (дөчинд дөрвөн сая дөрвөн зуун далан найман мянга таван зуу) төгрөгөөр Монгол фарм ХХК-иар, 26 дугаар багц шээсний шинжилгээний урвалжыг 38955000 (гучин найман сая есөн зуун таван таван мянга) төгрөгөөр Сетунари ХХК-иар, 27 дугаар багц нүдний эм, эмнэлгийн хэрэгслийг 17274180 (арван долоон сая хоёр зуун далан дөрвөн мянга нэг зуун наян) төгрөгөөр Царамтэнгэр ХХК-иар, 28 дугаар багц шүдний эм бэлдмэлийг 10587300 (арван сая таван зуун наян долоон мянга гурван зуу) төгрөгөөр Дэс ХХК-иар, 31 дүгээр багц гэмтлийн багаж, дагалдах хэрэгслийг 20780000 (хорин сая долоон зуун наян мянга) төгрөгөөр Мөнгөнгөлтгөнө ХХК-иар тус тус нийлүүлүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч, гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун)-д зөвшөөрсүгэй.

3. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн бараа нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж тайланг нэгтгэн танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

011100230

4. Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ нь захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн 1 дүгээр багц халдварын ба нянгийн эсрэг бэлдмэлүүд, 2 дугаар багц нойрсуулах ба булчин суллах, өвчин намдаах эм, бэлдмэлүүд, 3 дугаар багц сэтгэц нөлөөт болон уналт, таталт, салга өвчнийг засах бэлдмэлүүд, 4 дүгээр багц сийвэн орлох, дуслaar хэрэглэх болон цусанд нөлөөлөх бэлдмэлүүд, 5 дугаар багц зүрх судас ба даралт бууруулах, шээлгэх эмүүд, 6 дугаар багц даавар, дотоод шүүрэл, хоол боловсруулах элэг цесний бэлдмэлүүд, 7 дугаар багц хавдрын эсрэг эмүүд, 8 дугаар багц арьсны өвчин болон мөөгөнцрийн эсрэг бэлдмэлүүд, 9 дүгээр багц амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх бэлдмэлүүд, 10 дугаар багц үжлийн эсрэг ба халдваргүйжүүлэх оношилгооны бодисууд, 11 дүгээр багц амин дэм эрдэс бодисууд, 12 дугаар багц зүү тариур, 14 дүгээр багц мэс заслын утас зүү, 15 дугаар багц төрөх нярайн хэрэгсэл, 16 дугаар багц нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, 19 дүгээр багц цусны банк, 21 дүгээр багц клиник лабораторийн урвалж, 25 дугаар багц нян судлалын урвалж, 29 дүгээр багц тан, 30 дугаар багц гемодиализын эм бэлдмэл нийлүүлэх багцуудыг тус тус хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ГАНБОЛД